МЭДЭЭ · 2025 оны 9-р сарын 16

Нийслэлийн прокурорын газрын мэдэгдэл



МЭДЭГДЭЛ

МЭДЭГДЭЛ

Прокурорын байгууллага, прокурорын мэргэжлийн үйл ажиллагаатай холбогдуулан зарим хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчинд тус байгууллагын ажил хэргийн нэр хүнд, тодорхой прокурорын нэр төрд халдах, аюулгүй байдалд заналхийлэх, шийдвэр гаргуулахаар дарамт үзүүлэх, хөндлөнгөөс нөлөөлөх, олон нийтийг зориудаар төөрөгдүүлэх, нийгмийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөх зорилготой хууль бус дуу-дүрсний бичлэг хийх, худал мэдээ, мэдээлэл тараах зэрэг үйл ажиллагаа хийгдэж байгаа тул энэхүү мэдэгдлийг гаргаж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас батлагдсан “Прокурорын чиг үүргийн удирдамж”-ийн 4 дэх хэсэгт “Прокурор мэргэжлийн чиг үүргээ аливаа айдас, дарамт шахалт, хөндлөнгийн нөлөөллөөс ангид хэрэгжүүлэх, энэхүү боломжийг төр хангана”,

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа хараат бус байна”,

Прокурорын тухай хуулийн 7 дугаар зүйлд “Прокурор шийдвэрээ хуульд нийцүүлэн хараат бусаар гаргана”, “Прокурорын шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулахад нь хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх, хууль бус шийдвэр гаргуулахаар дарамт үзүүлэхийг хориглоно”, “Прокурорын байгууллагын үйл ажиллагаанд албан тушаалтан, хүн, хуулийн этгээд хууль бусаар нөлөөлөх, хөндлөнгөөс оролцохыг хориглоно” гэж тус тус зааж, прокурорын хараат бусаар ажиллах эрх зүйн баталгааг тодорхойлсон.

Прокурор хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хөндлөнгийн нөлөөллөөс ангид, хараат бусаар, хуульд захирагдан, хүний эрх, эрх чөлөөг хамгаалж ажиллах нь дэлхийн аль ч улс орны прокурорын үйл ажиллагааны үндсэн зарчим байдаг бөгөөд бид энэ зарчмыг чанд сахин ажилладаг.

Прокурорын хараат бус байдлыг хангах нь хууль дээдлэх, шударга ёсыг хэрэгжүүлэх баталгаа болох тул уг баталгааг алдагдуулах аливаа үйлдлийг хууль тогтоомжоор хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэдэг. Энэ хариуцлага нь нийтийн ашиг сонирхол, шударга ёсыг хамгаалах зорилготой юм.

Монгол Улсын Үндсэн хуульд тунхагласан шүүх эрх мэдэл, түүний дотор прокурорын байгууллагын үйл ажиллагаа, прокурорын шийдвэрт хуулийг дээдлэн хүндэтгэлтэй хандах учиртай.

НИЙСЛЭЛИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР
2025.09.16

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/902